



ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ИШ-ЁНДОН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.23 № 01/41

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрцогт сумын тусгай зориулалтын сангуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 149,692,191.00 /Нэг зуун дөчин есөн сая зургаан зуун ерэн хоёр мянга нэг зуун ерэн нэг / төгрөгийн дараах зөрил илэрлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 149,692,191.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-д /Байгууллага иргэдтэй үүссэн материал дүнтэй буюу насжилт өндөртэй, авлага өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

1791000712

2. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 03 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Засаг дарга /Б.Иш-Ёндон/, нягтлан бодогч /Б.Ууганцэрэн/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



С.ЖАЛБАА

ДАРГА

Б.ИШ-ЁНДОН

НЯГТЛАН БОДОГЧ

Б.УУГАНЦЭРЭН

ЗӨВШӨӨРСӨН:



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.